

**2019 ОНЫ 7 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 6 байгууллага /УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн. УХТЭ, ГССҮТ, УАУХТ эмнэлгүүд хүлээгдлийн мэдээ ирүүлээгүй байна.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2019 оны 7 дугаар сард СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна. УНТЭ 94, УГТЭ 55, ХСҮТ 218 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн 6 кабинетэд нийт 94 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 1007 үйлчлүүлэгчийн хүлээгдээр буурсан байна. Үүнд: Бөөрний кабинет 14, зүрх судасны кабинет 17, мэдрэлийн кабинет 18, нүдний кабинет 23, нүдний даралтын кабинет 8, чих хамар хоолойн кабинет 14 хүлээгдэл тус бүр 2-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УГТЭ-т нийт 55 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

Үүнд: Зүрх судасны кабинетэд 18, чих хамар хоолойн кабинетэд 18, хоол боловсруулах эрхтэн системийн кабинет 16, мэдрэлийн мэс заслын кабинет 3 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 13 кабинетэд 330 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 218 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: Бөөрний кабинет 1, зүрх судасны кабинет 14, цээжний хөндийн мэс засал 16, элэг цөс нойр булчирхайн кабинет 51, толгой хүзүүний мэс заслын кабинет 19, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 19, гепатологийн кабинет 14, туяа эмчилгээний кабинет 19, хими эмчилгээний кабинет 31, хөнгөвчлөх 4, ангиографийн кабинет 30 үйлчлүүлэгч тус бүр 2-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 114 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УНТЭ, УГТЭ-ийн 2019 оны 7-р сарын амбулаторийн хүлээгдлийг
үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 7-р сарын амбулаторийн хүлээгдлийг
үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 7 дугаар сард УНТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад 205 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 325 үйлчлүүлэгч байна.

УНТЭ-т оношлуулахаар 49 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна.

Үүнд: Рентген зураг 3, хэвлийн эхо 28, ходоодны дуран 6, захын судасны ЭХО 6, урологийн оношилгооны дуран 6 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т оношлуулахаар 42 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд: Рентген зураг 18, хэвлийн эхо 24 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 110 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 217 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 85 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 85, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 47 үйлчлүүлэгч байна. Нийт хүлээгдэл 262 байна.

Үүнд: Ходоодны дуран 12, хэвлийн ЭХО 61, зүрхний цахилгаан бичлэг 13, бүдүүн шулуун гэдэсний дуран 2, рентген харалт 22 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


Өдөртөө үйлчлүүлсэн 85 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 90 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 65 өдөртөө, 23 үйлчлүүлэгч 1 хоног, 2 үйлчлүүлэгч 2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 65 үйлчлүүлэгч байна.

ЭХЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 7-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 7 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.


УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

Лабораторийн нийт хүлээгдэл 364, өдөртөө үйлчлүүлсэн 215 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн хүлээгдэл 149 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 78, биохимийн шинжилгээ 59 үйлчлүүлэгч, иммунологи 12 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 215 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 7-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 7 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ ЭХЭМҮТ бүртгэн мэдээлсэн.

Нийт хүлээгдэл 524 үйлчлүүлэгч хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. ЭХЭМҮТ, УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УГТЭ-т 7-р сард нийт 115 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөрний тасагт 18, зүрх судасны тасагт 14, зүрхний мэс заслын тасагт 4, чих хамар хоолойн тасагт 45, мэдрэлийн тасагт 4, мэдрэлийн мэс засалд 28, мэс заслын тасагт 2 үйлчлүүлэгч тус тус 3-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 7-р сард нийт 240 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 60 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 91 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 58 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 31 үйлчлүүлэгч байна. Ерөнхий мэс заслын тасаг 4, элэг цөс нойр булчирхайн тасаг 40, хөнгөвчлөх эмчилгээ 16, хими эмчилгээ 147, ангиограф 33 үйлчлүүлэгч 3-30 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн 7-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 78 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

Үүнд: 21 үйлчлүүлэгч 3-6 хоног, 28 үйлчлүүлэгч 7-14 хоног, 15 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 15 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (2019 оны 7 сар):



Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 86, ЧДЭМТ-ийн дотор 93, БЗДНЭ-ийн дотор 141, ахмадын эмнэлэг 82 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 7-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

**Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 7 сарын хэвтүүлэн
эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ**


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	7 дугаар сар										
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн н эмнэлэг
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	40	16	7	7	7	12	0	0	0	0	0
		1-3 хоног	8	9	4	7		1					
		3-6 хоног	15	5	3		4	3					
		7-14хоног	15	2			3	8					
		15-30 хоног	2										
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	86	45	93	46	6	18	141	0	0	0	0
		1-3 хоног	1	25	47	18		1	41				
		3-6 хоног	11	11	35	15	4	11	33				
		7-14хоног	45	9	11	7	2	6	32				
		15-30 хоног	29			6			35				
		1 сараас дээш											
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	82	0	0	0	0	37	0	0	0	0	0
		1-3 хоног						10					
		3-6 хоног						5					
		7-14хоног	22					17					
		15-30 хоног	60					5					
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар	7 сар
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											

		15-30 хоног											
		1 сараас дээш											
7	Нарколог-ийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	111
		1-3 хоног											50
		3-6 хоног											31
		7-14хоног											25
		15-30 хоног											5
		1 сараас дээш											

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 7-р сард 24826 дуудлага бүртгэгдсэний 40.9%-ийг 0-20 минутад, 34.6%-ийг 21-40 минутад, 15.0%-ийг 41-60 минутад, 9.6 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 7 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 0,2%-иар нэмэгдсэн, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 3.2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны 1-7 саруудад ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА